

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Өргөдлийн байнгын хорооны 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

Хэлэлцсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн талаар иргэнээс ирүүлсэн өргөдлийн тухай

Шийдвэрлэсэн нь:

1. Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 258 тоот тушаалаар баталсан “Нэмэгдэл олгох тухай” журамд дараах чиглэлээр өөрчлөлт оруулахыг Засгийн газарт чиглэл болгов.

а/ журамд заасан нэмэгдлийг олгохдоо ажил олгогч байгууллагын ажлын байранд тавигдах шаардлагыг харгалздаг байх,

б/мэргэжлээрээ ажиллаж буй гэдэгт ямар ажлын байрууд хамаарахыг тодорхой болгон зохицуулах.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.БУРМАА

БАЙНГЫН ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Х.БАТТӨГСӨХ